



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2019 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 41

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,  
худалдах тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн 77.2.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дахь хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 13,800,000 /арван гурван сая найман зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 39-68 ДУА улсын дугаартай УАЗ-452 маркын автомашины худалдах доод үнийг 1,500,000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгөөр тогтоон дуудлага худалдаанд оруулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар / С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын даргын түр орлон гүйцэтгэгч Э.Сувдад даалгасугай.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга ( О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР